



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/71

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны 9 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Таван толгой түлш" ХХК-ийн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах сайжруулсан шахмал түлшний баруун бүсийн үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн сумын 1 дүгээр багийн нутагт байрлах зүүн бүсийн үйлдвэр рүү шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, зардлын тооцоог боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Эрдэмбилэг:

-Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Гишүүд:

Т.Батдондог

-Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Дулааны хэлтсийн дарга

Д.Даваасүрэн

-Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч

М.Гансүх

-Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч

Б.Эрдэнэбат

-“Эрчим хүчний хөгжлийн төв” Төрийн өмчит үйлдвэрийн газрын Зураг төсөл, магадлалын хэлтсийн дарга

Ш.Энхбаатар

-“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” Төрийн өмчит үйлдвэрийн газрын Зураг төслийн хэлтсийн дарга

М.Ганбаатар

-“Таван толгой түлш” Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал

Д.Болдбаатар

-“Таван толгой түлш” Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн баруун бүсийн үйлдвэрлэлийн албаны инженер

М.Жавхлан

-“Таван толгой түлш” Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн зүүн бүсийн үйлдвэрлэлийн албаны ерөнхий инженер


170600181

Нарийн бичгийн дарга
П.Давааням

-Түлшний бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын мэргэжилтэн

2.Баруун бүсийн үйлдвэрийг шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө,
зардлын тооцоог урьдчилсан байдлаар боловсруулж танилцуулахыг Ажлын хэсэг
/Ж.Эрдэмбилэг/-т үүрэг болгосугай.

САЙД



A handwritten signature in black ink, appearing to read 'N. TAVINBAY', is written over a faint pink rectangular stamp. The signature is stylized and extends downwards beyond the bottom edge of the stamp.

Н.ТАВИНБЭХ